



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

УЛААНБААТАР ХОТ  
2024 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ  
(2024 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр)

2024 оны 11 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх 1 тэргүүлэх зорилтын 5 зорилт, 10 арга хэмжээ тусгагдсан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна”, “3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ”, “3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна” зорилтуудад тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг 2024 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр гарган тайлагнав.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Тэргүүлэх зорилт:3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

**Зорилт: 3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.**

**3.4.1.1. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ.**

**Биелэлт:** Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг үе шаттайгаар нэмэгдүүлж Жанжин Д.Сүхбаатарын талбайд үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг шинээр байгуулж 2024 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлээ.



Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг 7 байршилд буюу “Төв шуудан”, жанжин Д.Сүхбаатарын талбай, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудалд байрлах төвүүд болон ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төвийг тогтмол, “Тэрэлж Монгол олле”, “Хонхор тосгон Монгол

олле”, “Сөүлийн гудамж Монгол олле” төвүүдийг улирлын чанартай ажиллуулж нийт 16,180 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.



Ж.СҮХБААТАРЫН  
ТАЛБАЙ




ЧИНГИС ХААН ОЛОН  
УЛСЫН НИСЭХ БУУДАЛ



ХБНГУ-ЫН ФРАЙБУРГ  
ХОТ




ТӨВ ШУУДАН



“СӨҮЛИЙН ГУДАМЖ  
МОНГОЛ ОЛЛЕ



ХОНГОР ТОСГОН  
МОНГОЛ ОЛЛЕ”



“ТЭРЭЛЖ МОНГОЛ  
ОЛЛЕ”

**3.4.1.2. Улаанбаатарын хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.**

**Биелэлт 1:** Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмолжуулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Франц соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Талын салхи” олон улсын мото наадам, “Плэйтийм” олон улсын хөгжмийн наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль”, “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”, “Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Гранд тур” зэрэг аялал жуулчлалын 15 эвент арга хэмжээг зохион байгуулж нийт гадаад, дотоодын 352,050 гаруй хүн үзэж сонирхсон. Үүнд:

#### **1. “Мазаалай” олон улсын цас мөсний наадам**

Аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг бууруулах, өвлийн улирлыг уртасгах, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадмыг 2024 оны 01 дүгээр сарын 14-28-ны өдрүүдэд “Скай резорт” цанын баазад зохион байгууллаа.

Монголын үндэсний бахархалт амьтан Мазаалайг хайрлан хамгаалах зорилгоор “Мазаалай мөсөн хотхон”-д 53 мазаалай, 50 метрийн урттай мөсөн гулсуур, 4000 м.кв мөсөн гулгалтын талбай, 12 метрийн өргөнтэй 18 метрийн урттай нэг цагт хамгийн олон хүн гулгах мөсөн гулсуур, Мазаалай бамбаруушнуудыг дүрсэлсэн 5 метр өндөртэй цас мөсөн баримлуудыг бүтээв.



“Мазаалай” олон улсын цас мөсний наадмын үеэр 12 метр өргөнтэй, 18 метр урттай мөсөн гулгуураар 1 цагийн дотор 408 хүн гулгаснаар Гиннесийн дээд амжилтыг тогтоож, Монгол орны өвлийн аялал жуулчлал дэлхийн газрын зурагт тэмдэглэгдсэн бөгөөд наадмын өдрүүдэд урлаг, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулж нийт 90,000 гаруй хүн “Мазаалай мөсөн хотхон”-оор үйлчлүүлэв.



## 2. “Улаанбаатарын өвлийн наадам”

Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн үндэсний болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам-2024” арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд “Скай резорт” цанын бааз, “Уухайн дуу” жуулчны бааз, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тус тус зохион байгуулж, Монгол туургатны мөсөн сурын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) хотын аварга шалгаруулах тэмцээн, Цасны Регбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөүбоардын тэмцээн зэрэг 5 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур зэрэг Монгол туургатан улсаас 34, Монгол Улсын 21 аймгаас 750, Улаанбаатар хотоос 332 нийт 1,114 тамирчин оролцов.

Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн сур, мөсний шагай, гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээн зохион байгуулж, урлагийн тоглолт, оpen mic, параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, тайга нохдын үзүүлбэр, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын 12,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



“Улаанбаатарын өвлийн наадам”



### 3. “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хот орчмын байгалийн үзэсгэлэн, соёл, ахуй байдлыг сурталчлан таниулах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай хамтран “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2024” арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд зохион байгуулав.

Фестивальд “Монголын явган алхалтын холбоо”-ны салбар холбоод буюу нийслэлийн 9 дүүрэг, Дархан-Уул, Орхон, Төв, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Баян-Өлгий, Увс зэрэг 10 аймгийн явган алхалтын клубүүдийн 600 гаруй алхагчид оролцож, 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Скай резорт цанын бааз буюу “Туул өртөө” хүртэл 10км, 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслангаас “Жавхлант өртөө” хүртэл 10км маршрутаар алхалт хийж, оролцогчдын дунд мөсөн шагайн тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.

“Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”







#### 4. “Бүргэдийн баяр”

Казах үндэстэн ястны ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 18 дахь жилдээ “Бүргэдийн баяр” арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулав.

Арга хэмжээнд Баян-Өлгий, Төв аймгуудаас 21 шилдэг бүргэдчинийг оролцуулан бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шьрга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Тайга анч нохдын үзүүлбэр”, шүхрийн үзүүлбэр болон тойром бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж “Бүргэдийн баяр-2024” арга хэмжээг гадаад, дотоодын 25000 гаруй хүн үзэж сонирхлоо.

“Бүргэдийн баяр”





## 5. “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль

Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, нүүдэлчдийн уламжлалт ёс заншлын салшгүй чухал соёлын өв болох бөөгийн ёс заншил, зан үйлийг олон нийтэд таниулах, соёл, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль арга хэмжээг “Тэнгэр тайлал” төрийн бус байгууллагатай хамтран 2024 оны 05 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд “Хүй долоо худаг” зохион байгууллаа. Арга хэмжээг тохиолдуулан 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Чингис хааны Үндэсний музей-ний хурлын танхимд зохион байгуулагдсан “Дэлхийн бөөгийн эрдэм шинжилгээний хурал”-д 300 гаруй бөө мөргөлчид, эрдэмтэн судлаачид оролцож бөөгийн үүсэл хөгжил, бөө тэнгэр шүтлэгийн хүн төрөлхтөнд үзүүлэх ач холбогдол, бөө өөрийн нутаг орон, байгалийнхаа төлөө хийх зан үйл зэрэг сэдвүүдийн хүрээнд илтгэл хэлэлцүүлэг зохион байгуулагдав.

“Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль арга хэмжээнд ОХУ, БНХАУ, Франц, Польш, Швед, АНУ, Канад, Бүгд Найрамдах Австри, БНСУ зэрэг 30 улсын 250, Монгол Улсаас 19 холбооны 500 нийт 750 бөө оролцож нар тахих ёслол, бөөгийн туг сүлд залах ёслол, тэнгэрийн дуудлага зан үйл, гал тахих ёслол зэрэг бөө мөргөлийн зан үйл үзүүллээ. Арга хэмжээний үеэр хүчит бөхийн барилдаан, хурдан морины уралдаан (соёолон нас), сурын харваа, шагайн харваа (өсвөрийн насны тамирчид) болон урлагийн тоглолт, шувуулахуйн үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулав. Арга хэмжээг гадаад, дотоодын 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо.

“Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль





## 6. “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд”

Франц хэлтэн орнуудын хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, “Аллианс Франсез” төвтэй хамтран “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр Франц хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг дипломат байгууллага, боловсрол, соёл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний 40 гаруй байгууллага үйл ажиллагаагаа танилцуулж, “Парис 2024” олимпын наадам болон Франц улсад суралцах, аялах талаар мэдээлэл өгч, соёл, урлагийн тоглолт, хоол үйлчилгээ зэрэг олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Арга хэмжээг гадаад, дотоодын 3,000 гаруй хүн үзэж сонирхсон.

“Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга




## 7. “Талын салхи” олон улсын мото наадам

Улаанбаатар хотод тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Скаллс” мото клубтэй хамтран “Талын салхи-2024” олон улсын мото наадмыг 9 дэх жилдээ “#SaveMazaalai” уриан дор 2024 оны 06 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон “Чингис хааны хөшөөт цогцолбор”-т зохион байгууллаа.

Мото фестивалд оролцогчид Энхтайваны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай, Бөхийн өргөө, Зүүн дөрвөн зам, Офицеруудын ордон, Амгалан өртөө, Баянзүрхийн товчоо, Налайх дүүрэг, Чингис хааны хөшөөт цогцолбор гэсэн маршрутаар 53 км мото парад зохион байгуулж, арга хэмжээнд БНХАУ, ОХУ, БНСУ, АНУ, Малайз, Вьетнам зэрэг улсуудаас 400 гаруй, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгийн 30 гаруй клубийн 1500 гаруй нийт 1900 гаруй мотоцикл сонирхогчид оролцов.

Арга хэмжээний үеэр Үндэсний бахархалт амьтан мазаалайг хайрлан хамгаалах “#SaveMazaalai” арга хэмжээ, оролцогчдын дунд гар барилдах, туг сүлжих, сээр шалгах, мото удаан явах зэрэг тэмцээн уралдаан болон мото түүний дагалдах хэрэгслийн үзэсгэлэн, гэр, майхан кемпийн үйлчилгээ, хоол, ундааны үйлчилгээ болон мото үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо.

“Талын салхи” олон улсын мото наадам




**8. “Плэйтайм” олон улсын хөгжмийн наадам**

Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Амьд хөгжмийн наадам” ТББ-тай хамтран “Плэйтайм-2024” олон улсын хөгжмийн наадмыг 22 дахь жилдээ 2024 оны 07 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр “Тайж хайрханы бэл”-д зохион байгууллаа.

“Плэйтайм-2024” олон улсын хөгжмийн наадамд гадаадын 21 улсын 52 хамтлаг, дуучид, Монгол Улсаас 250 гаруй хамтлаг дуучид нийт 800 гаруй хамтлаг, уран бүтээлчид 4 өдрийн турш 15 тайзнаас уран бүтээлээ хүргэж арга хэмжээг гадаад, дотоодын 71,000 гаруй хүн үзэж сонирхсон. Наадмын үеэр болон бэлтгэл ажилд 4000 гаруй түр ажлын байр бий болгож, 200 аж ахуй нэгж, байгууллага хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ үзүүллээ.

“Плэйтайм” олон улсын хөгжмийн наадам







### 9. “Дээлтэй Монгол наадам”

Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Үндэсний хувцасны өдрийг тохиолдуулан “Дээлтэй Монгол наадам-2024” арга хэмжээг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, баярын жагсаалд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг, Ордос аймаг, Баруун Үзэмчин хошуу, Шинжаан Уйгарын Өөртөө засах орны монголчууд, ОХУ-ын БНБуриад Улс, БНХалимаг Улс зэрэг бүс нутгаас 150 гаруй Монгол туургатны төлөөлөл, 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг болон 18 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 4826 хүн оролцлоо.

Арга хэмжээнд оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг дээл урлаач, гадаадын шилдэг эрэгтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 12 номинациар шилдгүүдийг тодруулав. Мөн арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын шоу үзүүлбэр, дээлтэй диско зэрэг арга хэмжээ, 6 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 138 иргэн, аж ахуй нэгж, байгууллага 40 асарт үндэсний дээл хувцас, эд хэрэглэлийн худалдаа үйлчилгээ зохион байгуулав. Арга хэмжээг гадаад, дотоодын 10,000 гаруй хүн үзэж сонирхсон.

“Дээлтэй Монгол наадам”







### 10. “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам

Монголчуудын уламжлалт өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, соёл, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор “Даншиг наадам-Хүрээ цам 2024” арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд хамтран 2024 оны 08 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд “Хүй 7 худагт” зохион байгуулав.

“Даншиг наадам-Хүрээ цам 2024” арга хэмжээний үеэр цам харайх ёслол, “Очирваань” бурхны тахилга, Эзэн Богд Чингис хааны тахилга үйлдэж, лам нарын дунд ном хэлэлцэх, мэтгэлцэх, балин тосон урлал, хурал номын ая эгшиг унзад голч нарын тэмцээн болон Үндэсний 256 бөхийн барилдаан, Буриад 64 бөхийн барилдаан, Өвөр-Монгол 64 бөхийн барилдаан, их нас, соёолон, жороо морьдын уралдаан, морьт харвааны тэмцээн, сээр шалгах тэмцээн, “Уухай” шагайн харвааны тойром, үндэсний сур харвааны тэмцээн тус тус зохион байгуулагдлаа.

Наадмын өдрүүдэд 200 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа, “Улаанбаатар 385 түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн”, 90 гаруй аж ахуйн нэгж, байгууллага хоол үйлдвэрлэл, хүнсний худалдаа үйлчилгээг зохион байгууллаа. Мөн соёлын хотхонд 9 дүүргийн 300 гаруй ардын авьяастнууд уран бүтээлүүдээ толилуулж, Монгол туургатан улсуудын урлаг соёлын тоглолтууд, залуучуудын бэсрэг наадам зэрэг урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулав. “Даншиг наадам-Хүрээ цам 2024” арга хэмжээг БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, Вьетнам, АНУ зэрэг гадаад улс орнуудаас 2700 жуулчин, Монгол Улсад суугаа 27 элчин сайдын яамны 100 гаруй зочид төлөөлөгчид, дотоодын 50,000 гаруй хүн үзэж сонирхсон.

“Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам







### 11. “Улаанбаатар фүүд фестиваль”

Монгол үндэсний хоол болон олон үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэд, жуулчдад таниулах, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “UB FOOD FESTIVAL-2024” арга хэмжээг 10 дахь жилдээ жанжин Д.Сүхбаатарын талбайд 2024 оны 08 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Фестивальд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 40 байгууллага Монгол, Япон, Солонгос, Энэтхэг, Тайланд, Мексик, Чех зэрэг үндэсний хоол, зууш болон кофе, амттанаар үйлчилгээ үзүүлж, Монголын тогооч нарын холбооны мастер тогооч нар хоолны шоу үзүүлбэр буюу дэлгэж шарсан хонь, 10 метрийн урттай пицца, 12 метр урттай шорлог хийж үзэгчдэд амтлуулав. “UB FOOD FESTIVAL-2024” арга хэмжээний үеэр 3 өдрийн турш хүүхэд, залуучууд, иргэд, жуулчдын дунд тахиа хэн хурдан идэх вэ?, бургер хэн хурдан идэх вэ?, амтыг таа, үнэрийг таа, ундаа хэн хурдан уух вэ?, хосын тэмцээн, дэмбээний тэмцээн, сэндвич хийх зэрэг 15 уралдаан, тэмцээн зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр циркийн тоглолт, DJ, жааз хөгжим, амьд хөгжмийн хамтлагийн тоглолт зохион байгуулж арга хэмжээг 3 өдрийн турш гадаад, дотоодын 25,000 гаруй хүн үзэж сонирхон.

“Улаанбаатар фүүд фестиваль”






## 12. “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”

Улаанбаатар хотод тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Улаанбаатар хот орчмын түүх соёл, өв уламжлал, ахуй байдал, байгалийн үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулах зорилгоор “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль 2024” (Ulaanbaatar Walking Festival) арга хэмжээг Монголын явган алхалтын холбоо, “Монгол Оллэ” нийгэмлэгтэй хамтран 2024 оны 08 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Фестивальд ОХУ, БНХАУ, БНСУ, БНЧУ, Филиппин улс, АНУ, БНКУ зэрэг гадаад улс орноос 140 гаруй, Монголын явган алхалтын холбооны салбар 21 аймаг, нийслэлийн 300 гаруй төлөөлөл нийт 450 гаруй алхагчид Налайх (Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газар), Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт тохижуулсан (Монгол олле алхалтын 1,2 дугаар зам) явган алхалтын 3 маршрутаар 3 өдрийн турш нийт 46 км замаар алхалт хийв.

“Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”



## 13. “Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд”

Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Лэтс Травел” ХХК хамтран “Японы соёл, аялал жуулчлалын өдөрлөг” (Japan festival) арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 24,25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.

Арга хэмжээний үеэр япон бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, боловсролын үзэсгэлэн, хоолны амталгаа, худалдаа зохион байгуулагдаж 20 гаруй аж ахуйн нэгж, байгууллага оролцож үйл ажиллагаагаа танилцууллаа. Япон улсаас 98 зочид төлөөлөгчид, 170 жуулчид зорин ирж оролцож Япон үндэсний хөгжмийн “Этосэтора” хамтлагийн тоглолт, Японы косплэй хувцасны үзүүлбэр, Япон дуу хэн сайн дуулах вэ” тэмцээн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Арга хэмжээг гадаад, дотоодын 12,000 гаруй хүн үзэж сонирхсон.



“Японы соёл, аялал жуулчлалын өдөрлөг”




#### 14. “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”

БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” (Korea Week) арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 30-аас 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, арга хэмжээнд БНСУ-ын Хойд Гёнсан мужаас 15, Жоннам мужаас 10, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй нийт 56 аж ахуй нэгж байгууллага оролцон үйл ажиллагаагаа танилцуулав.

Арга хэмжээнд БНСУ-аас 198 зочид, төлөөлөгчид оролцож БНСУ-ын “Юн Мён Хва” хамтлагийн Солонгос үндэсний бүжгийн тоглолт, "НУМУРИ" хамтлагийн амьд хөгжмийн тоглолт, Солонгос ардын урлагийн үзүүлбэр, электрик үндэсний хөгжмийн тоглолт, Жинду бөмбөрт бүжиг, таеквондогийн үзүүлбэр зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Арга хэмжээг гадаад, дотоодын 33,000 гаруй хүн үзэж сонирхсон.

“Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээ







### 15. “GRAND TOUR 2024” аялал жуулчлалын улсын олимпиад

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгтэй хамтран “GRAND TOUR 2024” аялал жуулчлалын улсын олимпиадыг 22 дахь жилдээ зохион байгууллаа.

Олимпиадыг “Tourism infographic” контент бүтээх тэмцээн, “Cesim service” бизнесийн загварчлалын цахим тэмцээн, “Grand Tour” спорт явган аяллын тэмцээн, “Центавр” мэргэжлийн мэдлэг, ур чадварын тэмцээн зэрэг 6 төрлийн тэмцээнд аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжилтэн бэлтгэдэг 18 их, дээд сургуулийн 800 гаруй оюутан оролцож хаалтын арга хэмжээг жанжин Д.Сүхбаатарын талбайд 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж амжилттай оролцсон их, дээд сургуулийн оюутнуудад шагналыг гардуулан өгч, “Mongolia Tourism-70” аялал жуулчлалыг сурталчлах үзэсгэлэн зохион байгуулагдлаа.

“GRAND TOUR 2024” аялал жуулчлалын улсын олимпиад





**Биелэлт 2:** “Визит Улаанбаатар” логог Улаанбаатар хотын сэтгүүл, хөтөч ном, нийслэл хотын газрын зураг зэрэг 3 төрлийн сурталчилгааны материал болон эвент арга хэмжээнүүдийн танилцуулга, контентуудад байршуулан олон нийтэд түгээн ажиллав.

Мөн Голден гоби болон зүймэл гар урлал, давуун урлалын 2 нэр төрлийн бүтээгдэхүүнд “Визит Улаанбаатар” логог ашиглан худалдаанд гаргасан.



**3.4.1.3. Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.**

**Биелэлт:** Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилгоор Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай хамтран “Плэйтийм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төсөл, Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх зэрэг 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

#### **1. “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажил**

Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилтын хүрээнд Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажлыг үргэлжлүүлэн 800 м урт хашаа, 21 амрах сандал, 8 сүүдрэвчтэй ширээ, 60 м.кв талбай бүхий ариун цэврийн байгууламж, бохирын байгууламж болон 1500 м урт явган хүний зам, 7 амрах цэг, 1400 м.кв талбай бүхий авто машины зогсоол, угтах хаалга зэрэг ажлыг хийж гүйцэтгүүлэв.







## 2. “Плэйтайм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төсөл

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай хамтран Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, зорин очих газрыг нэмэгдүүлэх зорилгоор “Плэйтайм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төслийг Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт эхлүүлэн 500,000 м.кв талбай бүхий газарт 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгууламжийн гадна талын 5000 м урт хашаа, 2500 м урт тусгаарлах хашаа барьж, цахилгаан, цэвэр усны эх үүсвэрийг шийдвэрлэн ариун цэвэр болон хог хаягдлын байгууламж, тохижилт бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж төслийн талбайд 58,000 ширхэг мод тарих ажлыг зохион байгууллаа.



## 3. “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх арга хэмжээ

Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, жуулчдын зорин очих газар болон маршрутын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын мэдээллийн сан үүсгэх, дотоодын аялагчдад зөв зохистой аялах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд хот орчмын байгалийн өвөрмөц тогтоц, үзэгдэл, зэрлэг амьтад, жигүүртэн



шувууд, цэцэг ургамал, түүх соёлын дурсгалт газрын гэрэл зургийг авах, шинэ аяллын зам гаргах, мэдээллийн самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах ажлууд хийгдэж байна. Тухайлбал Бэлхийн амаас- Батсүмбэр хүртэл 15 км, Шарга морьт зусланд 7,5 км, Бэлхийн амны хүннүгийн цогцолборт 6,5 км, Их баян зусланд 7,5 км аяллын маршрутыг шинэчлэн гаргаж замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах ажлыг гүйцэтгэж байна




**Зорилт: 3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацийг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.**

**3.4.2.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад, дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ.**

**Биелэлт:** Аялал жуулчлалын эвент арга хэмжээ “Улаанбаатар өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Талын салхи” олон улсын мото фестиваль, Плайтайм олон улсын амьд хөгжмийн наадам, “Дээлтэй монгол” наадам, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль” зэрэг арга хэмжээнүүдтэй холбоотой 17 контент хийж байгууллагын цахим хуудас [www.tourism.ub.gov.mn](http://www.tourism.ub.gov.mn), [www.visitulaanbaatar.net](http://www.visitulaanbaatar.net) болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд байршуулж 2,734,679 хүнд хүргэсэн. News.mn, Ikon.mn, Gogo.mn, Zarig.mn зэрэг 20 вэбсайтаар олон нийтэд сурталчлан, арга хэмжээнүүдтэй холбоотой 29 удаагийн контент, зураг, дүрс бичлэгийг олон нийтэд түгээж нийт 1,849,231 хүнд хүргэсэн.







### 3.4.2.2. Улаанбаатар хотыг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцож, сурталчлан таниулна.

**Биелэлт:** “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, тур оператор компаниудтай хамтран “ITB BERLIN-2024”, “SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024”, “TRAVEL EXPO JAPAN-2024”, “Улаанбаатар трaвeл экспo-2024”, “ITM- МОНГОЛИА-2024” зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүд болон БНХАУ-ын Гуан-жуо, Хонконг, Бээжин хотуудад зохион байгуулсан “GO MONGOLIA-ROAD SHOW 2024” арга хэмжээ зэрэг нийт 8 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон. Үүнд:

#### “ITB Berlin 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, Европын орнуудаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор ХБНГУ-ын Берлин хотноо 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 58 дахь удаагийн “ITB Berlin 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд дэлхийн 200 гаруй орны 5,500 төлөөлөгчид оролцож “Адал явдалт аялал ба хариуцлагатай аялал жуулчлал”, “Бизнес аялал”, “Ажил мэргэжлийн төв - Судалгаа, ажил, хэтийн төлөв”, “Соёлын аялал жуулчлал” сэдвүүдийн хүрээнд илтгэл, хэлэлцүүлэг, арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа.

Монгол Улсаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон “МИАТ” компани, “Grace A Star Mongolia”, “New Juulchin tours”, “Juulchin”, “Tsolmon Travel”, “Nona travel Mongolia”, “Golden Gobi Tours & Expedition”, “Great Genghis Tours and Expeditions”, “Ragusa tour”, “Explore Mongolia”, “Blue Silk travel”, “Twin World” зэрэг 11 тур оператор компаниуд хамтран оролцож, B2B уулзалтууд зохион байгуулж үйл ажиллагаагаа сурталчлан ажиллалаа.

#### “ITB Berlin 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн







### “SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

БНСУ-ын Сөүл хотод 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 39 дахь удаагийн “SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 40 гаруй улс орны 400 гаруй байгууллага оролцлоо.

Монгол Улсаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон 10 тур оператор компаниуд хамтран оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчиллаа. Арга хэмжээний үеэр 2024 онд Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улсын болон үндэсний хэмжээний эвент арга хэмжээнүүдийн нэгдсэн танилцуулгыг оролцогчдод хүргэж, Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолт зохион байгуулав.

“SITF” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс “GO MONGOLIA” аялал жуулчлалын брэндийгээ сурталчлан танилцуулж “Шилдэг PR маркетингтай Booth”-ээр шалгарлаа.

### “SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн








### “Travel Expo Japan-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Япон Улсын Токио хотод 2024 оны 09 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Travel Expo Japan-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд “Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо”, “Монгол–Японы аялал жуулчлалын холбоо, “ЖАЙКА” Олон улсын байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “МИАТ” ХК болон 10 тур оператор байгууллага хамтран оролцлоо.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас Улаанбаатар хотод тогтмол зохион байгуулагддаг эвент арга хэмжээний видео танилцуулга, Улаанбаатар хотын сурталчилгааны 300 ширхэг сэтгүүлийг (япон хэлээр хэвлэгдсэн) оролцогч нарт хүргэж, 2 өдрийн үндэсний урлагийн тоглолтыг хариуцан зохион байгуулж үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан.

“Travel Expo Japan- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн





### “GO MONGOLIA” ROAD SHOW-2024 цуврал арга хэмжээ

Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яам, Монгол Улсаас БНХАУ суугаа Элчин сайдын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, “Хүннү Айр” ХХК-тай хамтран “GO MONGOLIA-ROAD SHOW 2024” арга хэмжээг БНХАУ-ын Гуан-жоу, Хонг конг, Бээжин хотуудад 2024 оны 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулж, 2024 онд Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улсын болон үндэсний хэмжээний эвент арга хэмжээнүүдийн нэгдсэн танилцуулгыг оролцогчдод хүргэж, Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолт зохион байгуулав. Арга хэмжээнүүдийн үеэр зохион байгуулагдсан 2 талын уулзалтад Монгол Улсын 21, БНХАУ-ын 175 аялал жуулчлалын тур оператор компаниуд хамтран гэрээ байгуулав.

“GO MONGOLIA” ROAD SHOW-2024



### “Улаанбаатар трافل экспо-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулж, аялагч, амрагчдад аяллын талаарх мэдээ, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар Аялал жуулчлалын



холбоотой хамтран “Улаанбаатар тревел экспо-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 10 дахь жилдээ 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгууллаа.

Үзэсгэлэнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын танхим, БНСУ-ын “Korea Tourism Organization”-ын харъяа 17 байгууллага, Монгол Улсаас Өмнөговь, Дархан, Ховд, Завхан, Увс зэрэг 5 аймаг болон аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид нийт 87 байгууллага аяллын дагалдах хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаагаа танилцуулав.

“Улаанбаатар тревел экспо-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн



### “ITM Монголиа-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Үндэсний соёл, аялал жуулчлал, технологийн хөгжил” уриа дор “ITM Mongolia-2024” (International Travel Mart) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2024 оны 10 дугаар сарын 25, 26, 27-ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 25 дахь жилдээ зохион байгууллаа. Үзэсгэлэнд 21 аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газар, аялал жуулчлалын холбоод болон үндэсний нислэгийн авиа компани, гадаад дотоодын аялал жуулчлалын тур оператор компани, жуулчны бааз, ресторан зоогийн газар, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгч, урлаг соёл, үзвэр үйлчилгээний 160 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан танилцуулж, үзэсгэлэнг 14,500 гаруй хүн үзэж сонирхсон.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас хотын автобустай аяллын бүтээгдэхүүнээ танилцуулж, Улаанбаатар хотын сурталчилгааны 8 төрлийн 5000 гаруй ширхэг сурталчилгааны материал тарааж үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан бөгөөд “Шилдэг тохижилттой” оролцогчоор шалгарлаа.





**Зорилт 3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.**

**3.4.3.1. Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.**

**Биелэлт:** Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай “Оюутан цагдаа-сургалт”, “Оюутан цагдаа-2024” арга хэмжээ, Жуулчны нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах, зорчих үйлчилгээг нэвтрүүлэх арга хэмжээ, “Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт”, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны баазуудын үйл ажиллагаанд хийсэн стандартын үзлэг шалгалт зэрэг 5 арга хэмжээг зохион байгууллаа. Тухайлбал:

1. Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, оюутан залуусыг түр ажлын байраар хангаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Монголын Оюутны холбоо хамтран “Оюутан цагдаа-2024” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 08 дугаар сарын 13-ны өдрийн хооронд 2 сарын хугацаанд хэрэгжүүлж, Улаанбаатар хотын 14 их, дээд сургуулийн 50 оюутан ажиллалаа.

Оюутан цагдаа нар ажиллах хугацаандаа Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 13, зөрчлийн шинжтэй 3213 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 16,178 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 17,255 иргэнд хэлмэрчилж, 5 төрлийн 20,500 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, 2600 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 136 бага насны хүүхдийг ар гэрт нь, 5 хүүхдийг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, Монгол орны байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний талаар 5 бүлэг 58 мэдээ, мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 16,981 жуулчдад танилцуулан ажилласан.





2. "Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох" сургалтыг жуулчны хөтөчид хамаарах хууль эрх зүй, дүрэм журам, жуулчныг угтах, үдэх, жуулчныг зочид буудалд буулгах, гаргах, жуулчны аюулгүй байдал, хөтөч тайлбарлагчийн ур чадвар, ослын тохиолдлууд, хөдөлгөөнт тээврийн хэрэгслээр жуулчныг аялуулах-тайлбар хүргэх нь сэдвүүдийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 22-ны хооронд зохион байгуулж 56 хөтөч тайлбарлагчийг, "Оюутан цагдаа-2024" арга хэмжээний сургалтыг хууль эрх зүй, жуулчны аюулгүй байдал, хөтөч тайлбарлагчийн ур чадвар, анхан шатны тусламж үйлчилгээ, оюутан цагдаагийн гүйцэтгэх үүрэг, эргүүлийн үүрэг гүйцэтгэх үед өөрийн аюулгүй байдлыг хангах нь зэрэг сэдвүүдийн хүрээнд 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж 50 оюутан цагдааг хамрууллаа.







3.Жуулчин тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, гадаад, дотоодын иргэд жуулчдын аюулгүй байдлыг хангах, зорчих үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор хотын төвөөс хөшгийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал хооронд нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор “Нью Улаанбаатар интернешнл эйрпорт” ХХК-ны удирдлагуудтай уулзах уулзалтыг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан. Уулзалтад Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Улаанбаатар Хөгжлийн корпораци”, “Тээврийн цаглаагийн алба”, “Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс” зэрэг байгууллагуудын удирдлагууд оролцсон бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс “Сүхбаатарын талбай-Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал”, “5 шар-Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал” гэсэн 2 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүллээ.



Х:19 “Чингис хаан Олон улсын нисэх буудал – Сүхбаатарын талбайн төв зогсоол”



Х:20 “Чингис хаан Олон улсын нисэх буудал – 5 шар”



**3.4.3.2. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.**

**Биелэлт:** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ын хүрээнд “Онлайн бизнес төв” нэгдсэн системд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудын бүртгэлийг нэмэгдүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Нийслэл хотын албан татварт 23,381.5 төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.

**3.4.3.3. Салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулна.**

**Биелэлт:** Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Гастро аялал-2024” сургалт, “Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт”, “Чингис



хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалт, “Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт”, “Оюутан цагдаа-2024 сургалт”, “Олон улсын хоолны жор технологи” сургалт зэрэг гадаад, дотоодын 6 төрлийн 18 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 865 хүнийг хамруулав. Үүнд:

- ✓ Олон үндэстний хоолны тогооч бэлтгэх “Гастро аялал 2024” сургалтын хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлал өндөр хөгжсөн БНСУ, Узбекистан улс, ОХУ, Турк, Тайланд, БНХАУ-ын Хонг Конг зэрэг 6 улсад 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж 56 хүн,
- ✓ Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 22-ны хооронд зохион байгуулж 56 хөтөч,
- ✓ Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 15,16 болон 29,30-ны өдрүүдэд зохион байгуулж 90 хүн,
- ✓ “Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт”-ыг 2024 оны 05 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд зохион байгуулж 163 хүн,
- ✓ “Гастро аялал-2024” сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар шатны дотоодын сургалтыг “Олон улсын хоолны жор технологи” сэдвийн хүрээнд 2024 оны 5 дугаар сарын 14-16, 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд үе шаттайгаар зохион байгуулж 450 хүн,
- ✓ “Оюутан цагдаа-2024” арга хэмжээнд ажиллах оюутнуудын сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж 50 оюутан хамрагдлаа.


“Олон үндэсний хоолны тогооч бэлтгэх” хөтөлбөрийн гадаад сургалт







“Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох” сургалт





“Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалт



“Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт”







“Гастро аялал-2024” сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар шатны дотоодын сургалт



ТАНИЛЦСАН:  
ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.ГАНБОЛД

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ